



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦӨГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠒᠐᠒᠒ оны ᠐᠕ сарын ᠒᠑ өдөр

Дугаар ᠕᠕᠕

Амардалай

Цагийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9.4.1, 9.4.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн санал хүсэлтийн дагуу сумын хэмжээнд худалдаа үйлчилгээ явуулдаг аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг 08.00 цагаас 21.00 цагаар тогтоосугай.

2. Нийтийг хамарсан их цэвэрлэгээний үед худалдаа үйлчилгээ явуулахыг түр зогсоож, өөрийн аж ахуйн нэгжийн ойр орчмоос 50 метр хүртэлх талбайг цэвэрлэж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Аж ахуй нэгж, байгууллагын удирдлагуудад даалгасугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулан ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (Л.Отгонбаатар), хэсгийн цагдаа (Т.Сод-Оргил), Байгаль орчны мэргэжилтэн (Б.Энхдэлгэр) нарт үүрэг болгосугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ

4880700502